БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/184/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:www.audit.mn<br><br>Баянхонгор аймаг<br>2022 оны 02 дугаар сар | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mm<br><br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mm<br><br>Ахлах аудитор: М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг Altantuyam@audit.gov.mm<br><br>Аудитор: Л.Доржханд<br>Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhandl@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

## Агуулга

2.Аудитын санал дүгнэлт /эх хувь/ ....2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....10
3. Аудитын тайлан....10
3.1 Ерөнхий зүйл ....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....11
3.4 Материаллаг байдал....12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....14
3.8 Аудитын гол асуудал....14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....14
3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт ....15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ....15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....15
4. Аудитын илрүүлэлт ....15
4.1 Аудитын зөвлөмж ....15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....17

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn
2022. 02. 25 № 2/62

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНХОНГОР СУМЫН 15 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.АДЪЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31 /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,272,658.00** | **89,882,867.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 40,272,658.00 | 89,882,867.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 38,480,658.00 | 65,403,180.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 36,692,958.00 | 62,057,680.00 |
| 35130 | Эм боох материал | 1,787,700.00 | 3,345,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 1,792,000.00 | 24,479,687.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 464,300.00 | 2,323,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,150,000.00 | 19,708,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 177,700.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 2,447,587.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **813,737,342.79** | **799,385,294.50** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 813,737,342.79 | 799,385,294.50 |
| **392** | **Биет хөрөнгө** | 813,180,009.53 | 799,003,961.28 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 758,400,000.00 | 758,400,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -12,639,999.96 | -25,279,999.92 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 47,758,890.00 | 47,758,890.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -16,388,362.81 | -26,916,745.21 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,896,479.41 | 69,687,961.91 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -14,846,997.11 | -24,646,145.50 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 557,333.26 | 381,333.22 |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -322,666.74 | -498,666.78 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **854,010,000.79** | **889,268,161.50** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **478,778.40** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 478,778.40 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 478,778.40 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 478,778.40 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **853,531,222.39** | **889,268,161.50** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 853,531,222.39 | 889,268,161.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 853,531,222.39 | 889,268,161.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 853,531,222.39 | 853,531,222.39 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 35,736,939.11 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **854,010,000.79** | **889,268,161.50** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31 /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **380,483,910.00** | **588,920,764.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,152,410.00** | **54,160,892.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,152,410.00 | 54,160,892.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 13,152,410.00 | 54,160,892.50 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,152,410.00 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгө | | 18,791,482.50 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-бараа материал | | 35,369,410.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **47,034,500.00** | **109,078,771.55** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 320,297,000.00 | 425,681,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 71,750,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 70,880,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 870,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 47,034,500.00 | 37,328,471.55 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 47,034,500.00 | 37,328,471.55 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **369,908,922.20** | **553,183,824.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **369,908,922.20** | **553,183,824.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 358,095,482.53 | 547,733,188.63 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 217,866,373.74 | 265,657,355.44 |
| 210101 | Үндсэн цалин | 201,574,386.74 | 228,725,530.66 |
| 210102 | Нэмэгдэл | 8,973,055.00 | 9,566,123.90 |
| 210104 | Урамшуулал | 7,318,932.00 | 27,365,700.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,446,174.72 | 34,777,417.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,700,236.02 | 24,258,408.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,255,815.31 | 2,690,173.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,755,411.94 | 2,135,338.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 430,310.13 | 516,401.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,304,401.32 | 5,177,095.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,508,913.27 | 36,828,471.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,821,803.77 | 3,733,597.55 |
| 210302 | Түлш, халаалт | 34,406,665.50 | 28,039,770.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,280,444.00 | 5,055,104.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,891,300.00 | 39,316,925.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 110,800.00 | 10,976,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,600,000.00 | 5,236,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,396,800.00 | 1,435,727.99 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 20,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 761,200.00 | 497,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,022,500.00 | 17,198,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 3,953,148.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,854,180.00 | 92,500,587.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 2,583,650.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,854,180.00 | 89,848,737.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 68,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,265,500.00 | 3,620,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 570,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,265,500.00 | 3,050,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 114,900.00 | 608,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 114,900.00 | 608,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 626,500.00 | 39,735,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 326,500.00 | 39,222,630.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 162,670.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27,521,640.80 | 34,689,030.79 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 665,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 880,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,521,640.80 | 33,143,530.79 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 11,813,439.67 | 5,450,636.31 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 122,700.00 | 2,120,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 122,700.00 | 2,120,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,525,586.73 | 200.00 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,525,586.73 | 200.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,165,152.94 | 3,330,436.31 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,165,152.94 | 3,330,436.31 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,574,987.80** | **35,736,939.11** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31 /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **367,331,500.00** | **534,759,871.55** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **367,331,500.00** | **534,759,871.55** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 320,297,000.00 | 425,681,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 71,750,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 70,880,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 870,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 47,034,500.00 | 37,328,471.55 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 47,034,500.00 | 37,328,471.55 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **351,172,400.00** | **534,759,871.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **351,172,400.00** | **534,759,871.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **339,358,960.33** | **529,309,235.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 219,696,047.06 | 266,136,433.10 |
| 210101 | Үндсэн цалин | 174,809,047.44 | 218,983,899.91 |
| 210102 | Нэмэгдэл | 22,507,189.62 | 19,786,532.31 |
| 210104 | Урамшуулал | 22,379,810.00 | 27,366,000.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,539,500.00 | 34,777,118.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,003,200.00 | 24,258,408.78 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,134,100.00 | 2,690,173.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,707,200.00 | 2,135,338.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 426,800.00 | 516,401.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,268,200.00 | 5,176,795.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,508,913.27 | 36,828,471.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,821,803.77 | 3,733,597.55 |
| 210302 | Түлш, халаалт | 34,406,665.50 | 28,039,770.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,280,444.00 | 5,055,104.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,152,300.00 | 40,798,347.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 110,800.00 | 1,525,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,600,000.00 | 14,620,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,396,800.00 | 1,358,397.99 |
| 210404 | Ном, хэвлэл | 61,400.00 | 320,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 865,000.00 | 497,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,118,300.00 | 22,477,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 39,169,800.00 | 48,967,484.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,846,000.00 | 4,106,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,913,500.00 | 31,471,084.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,410,300.00 | 13,390,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,615,200.00 | 16,784,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 870,000.00 | 3,200,000.00 |
| 210602 | Тавилга | 57,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,688,200.00 | 13,584,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 114,900.00 | 608,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 114,900.00 | 608,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 626,500.00 | 73,393,430.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 326,500.00 | 72,803,430.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,935,800.00 | 11,015,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 4,295,950.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,935,800.00 | 6,719,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,813,439.67** | **5,450,636.31** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 122,700.00 | 2,120,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 122,700.00 | 2,120,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,525,586.73 | 200.00 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,525,586.73 | 200.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,165,152.94 | 3,330,436.31 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,165,152.94 | 3,330,436.31 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **16,159,100.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **16,159,100.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **16,159,100.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 16,159,100.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 16,159,100.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-16,159,100.00** | **00.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31 /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **853,531,222.39** | **00.00** | 853,531,222.39 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **853,531,222.39** | **00.00** | 853,531,222.39 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **853,531,222.39** | **00.00** | 853,531,222.39 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 35,736,939.11 | 00.00 | 35,736,939.11 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **889,268,161.50** | **00.00** | 889,268,161.50 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31 /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 464,711,400.00 | 459,679,135.24 | 5,032,264.8 | 98.92 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 464,711,400.00 | 459,679,135.24 | 5,032,264.8 | 98.92 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 462,590,900.00 | 457,559,135.24 | 5,031,764.8 | 98.91 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 267,938,100.00 | 266,136,433.10 | 1,801,666.9 | 99.33 |
| 210101 | Үндсэн цалин | 220,385,700.00 | 218,983,899.91 | 1,401,800.1 | 99.36 |
| 210102 | Нэмэгдэл | 19,621,100.00 | 19,786,532.31 | -165,432.3 | 100.84 |
| 210104 | Урамшуулал | 27,931,300.00 | 27,366,000.88 | 565,299.1 | 97.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,208,100.00 | 34,777,118.60 | 1,430,981.4 | 96.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,138,000.00 | 24,258,408.78 | 2,879,591.2 | 89.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,267,500.00 | 2,690,173.51 | -422,673.5 | 118.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,814,100.00 | 2,135,338.99 | -321,239.0 | 117.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 453,500.00 | 516,401.47 | -62,901.5 | 113.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,535,000.00 | 5,176,795.85 | -641,795.9 | 114.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,530,300.00 | 36,828,471.55 | 1,701,828.5 | 95.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,108,700.00 | 3,733,597.55 | 375,102.5 | 90.87 |
| 210302 | Түлш, халаалт | 28,041,600.00 | 28,039,770.00 | 1,830.0 | 99.99 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,380,000.00 | 5,055,104.00 | 1,324,896.0 | 79.23 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,807,400.00 | 40,798,347.99 | 9,052.0 | 99.98 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,508,400.00 | 1,525,650.00 | -17,250.0 | 101.14 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,620,000.00 | 14,620,000.00 | 0.0 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,395,200.00 | 1,358,397.99 | 36,802.0 | 97.36 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 360,200.00 | 320,000.00 | 40,200.0 | 88.84 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 497,000.00 | 3,000.0 | 99.40 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,423,600.00 | 22,477,300.00 | -53,700.0 | 100.24 |
| **2105** | **Норматив зардал** | 48,967,500.00 | 48,967,484.00 | 16.0 | 100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,106,200.00 | 4,106,200.00 | 0.0 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,471,100.00 | 31,471,084.00 | 16.0 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,390,200.00 | 13,390,200.00 | 0.0 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,784,700.00 | 16,784,700.00 | 0.0 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,200,000.00 | 3,200,000.00 | 0.0 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,584,700.00 | 13,584,700.00 | 0.0 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 612,400.00 | 608,000.00 | 4,400.0 | 99.28 |
| 210702 | Дотоод албан томилолт | 612,400.00 | 608,000.00 | 4,400.0 | 99.28 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,723,100.00 | 1,643,330.00 | 79,770.0 | 95.37 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,133,100.00 | 1,053,330.00 | 79,770.0 | 92.96 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 350,000.00 | 0.0 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 | 0.0 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11019300.00 | 11015250.00 | 4,050.0 | 99.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,300,000.00 | 4,295,950.00 | 4,050.0 | 99.91 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,719,300.00 | 6,719,300.00 | 0.0 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2120500.00 | 2120000.00 | 500.0 | 99.98 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,120,500.00 | 2,120,000.00 | 500.0 | 99.98 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,120,500.00 | 2,120,000.00 | 500.0 | 99.98 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 464,711,400.00 | 459,679,135.24 | 5,032,264.8 | 98.92 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 425,681,100.00 | 422,350,663.69 | 3,330,436.3 | 99.22 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 425,681,100.00 | 422,350,663.69 | 3,330,436.3 | 99.22 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 39,030,300.00 | 37,328,471.55 | 1,701,828.5 | 95.64 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 39,030,300.00 | 37,328,471.55 | 1,701,828.5 | 95.64 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30.00 | 28.00 | 2.0 | 93.33 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.0 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21.00 | 19.00 | 2.0 | 90.48 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 8.00 | 0.0 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 145.00 | 145.00 | 0.0 | 100.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 145.00 | 145.00 | 0.0 | 100.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 145.00 | 145.00 | 0.0 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31 /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0.00 | **71,750,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0.00 | **71,750,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 71,750,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 71,750,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 71,750,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 200.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.00 | **200.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 200.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 71750300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 71,750,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 70,880,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 870,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэзням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 92 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Адъяа, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл нягтлан бодогч Ж.Оюунчимэг, 2021оны 11 дүгээр сарын 14-ны өдрөөс Б.Даваажаргал хоёрдугаар гарын үсгийг зурсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэг нь хүүхэд багачуудад сургуулийн өмнөх боловсрол олгох, аймгийн БСУГ-аас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс хичээл, сургалтыг үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүрэгтэй.

Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэг нь: Боловсрол, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Чадварлаг багш", "Сайн багш" ,"Хос бичигтэн" дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, сургалтын орчин сайжруулан, багшийн хөгжлийг дэмжиж, удирдах ажилтан, багш нарын ажлын хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд 4 бүлэгт 160 хүүхэд хамрагдаж, 30 орон тоотойгоор ажилласан бөгөөд 464,711.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын даргын 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн баталсан нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын зөвлөх үйлчилгээг 2021.11.29-ны өдөр хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 369,908.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,699.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,774.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,188.9 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 15 дугаар Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35258.2 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 40,272.7 | 89,882.9 | 49,610.2 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 40,272.7 | 89,882.9 | 49,610.2 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 813,737.3 | 799,385.3 | (14,352.0) |
| Үндсэн хөрөнгө | 857,935.4 | 876,726.9 | 18,791.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (44,198.0) | (77,341.6) | (33,143.5) |
| **Нийт хөрөнгө** | 854,010.0 | 889,268.2 | 35,258.2 |
| Өр төлбөр | 478.8 | - | (478.8) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 853,531.2 | 889,268.2 | 35,736.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 854,010.0 | 889,268.2 | 35,258.2 |

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 175,220.5 мянга, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй шилжүүлсэн авсан 5,525.0 мянга, аймгийн Онцгой комиссоос үнэ төлбөргүй олгосон постын шатахуун, хүнсний материалын үнэ 29,114.4 мянга, сумын Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгосон нэг удаагийн хамгаалах хэрэгсэл 510.0 мянга нийт 210,589,9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд бараа материалын дансны үлдэгдэл 89,882.9 мянган төгрөг болж 49,610.2 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,859.3 мянга, аж ахуйн материал 18,558.5 мянга, хүнсний материал 2,447.6 мянга, эм боох материал 1,557.8 , тусгай зориулалтын материал 25,364.7 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 889,268.2 мянган төгрөг болж 35,258.2 мянган төгрөгөөр өссөн БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 17,146.2 мянга, ажилчдын хандиваар буй болсон 1,645.3 мянга, нийт 18,791.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэсэнтэй холбоотой бөгөөд тайлант онд үндсэн хөрөнгийн зарлага гараагүй байна.

Өмнөх оны ХХОАТ-ын өрийг тайлант онд барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 889,268.2 мянган төгрөг болж 35,258.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 35,258.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх зарлагыг 458,587.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 71,011.7 мянган төгрөгөөр бууруулж 387,575.3 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 4 удаа өөрчлөлт хийж 2021 оны 12 дугаар сард 464,711.4 мянган төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 383,749.7 мянга, орон нутгийн төсвөөс 38,873.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 425,681.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 39,030.3 мянга, нийт 464,711.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 459,679.2 мянган төгрөгийг зарцуулж 5,032.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 70,880.3 мянган төгрөгийн санхүүжилт, өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилт 870.0 мянган төгрөг нийт 71,750.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, аймгийн Засаг даргын 2021.10.04-ны өдрийн А/620 дугаартай захирамжийн дагуу тусгаарлан эмчлүүлэх байранд эмчлүүлсэн иргэдийн зардал, аж ахуйн материал худалдан авахад 870.0 мянга нийт 71,750.1 мянган төгрөгийн зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 0,2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго 23 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймаг, сумын онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 553,183.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 183,274.9 мянган төгрөгөөр буюу 49.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 534,759.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 424,454.8 мянган төгрөгийн 146 мэдээллийг хугацаанд нь, 110,305.1 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

*Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 93 | 3 | |
| | Нийт | 27 | 151 | 146 | 3 | 2 |

*Эх сурвалж:Шилэн дансны нэгдсэн системээс*

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд 464,711.4 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 459,679.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал болох 122,034.9 мянган төгрөгөөс 10 хувь болох 12,203.5 мянган төгрөг хэмнэхээс 3,330.4 мянган төгрөгийг хэмнэж 8,873.1 мянган төгрөгийг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 38,530.3 мянган төгрөгөөр баталж 36,828.5 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 7,706.1 мянган төгрөг хэмнэхээс 37.5 мянган төгрөгийн хэмнэлт гарган 7,668.6 мянган төгрөг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

### 3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,871.7 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 870.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага 6,501.7 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж хүргүүлснийг өгсөн бөгөөд хэрэгжилтийг Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн 2021.03.15-ны өдрийн 18 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 119,941.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 973.7 мянган төгрөгийн 3 алдаанд төлбөрийн акт, 118,968.0 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын даргын 2021.12.14-ны өдрийн "Короновирусын халдвар цар тахлын үед ажилчдад дэмжлэг үзүүлэх тухай" 45 дугаартай тушаалаар олгосон түлшний хөнгөлөлт 1,200.0 мянга, витамины үнэ 680.0 мянга, нийт 1,880.0 мянган төгрөгийг бэлэн мөнгөөр

гаргасан боловч кассын тайлан гаргаагүй, тараасан жагсаалтад хүлээн авсан гарын үсэг дутуу, орлогоос 10% суутгаагүй байна.

Энэ нь ХХАОТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1."Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасныар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна", санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "Үнэн зөв, үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажиллагсдаас дутуу суутгасан ХХАОТ-ын 188.0 мянган төгрөгийг суутган авч орон нутгийн төсөвт төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

2. Нягтлан бодогч өмнөх оны засварын материалын үлдэгдэл 177.7 төгрөгийн материалыг нярав тайлан гаргаагүй байхад зарлага болгож, тооллогоор тоологдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", санхүүгийн тайлангийн "бодитой оршин байх", "Эрх ба үүрэг" Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шууд зардлаар бүртгэсэн засварын материалын 177.7 мянган төгрөгийг нягтлан бодогчоор төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

3. Тус байгууллагын дарга, 5 багшийн хамт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 157 дугаар Цэцэрлэгээс туршлага судлах ажлаар 2021.10.01-02-ны өдрүүдэд ажиллахаар 608.0 төгрөгийн албан томилолт авч явсан ба томилолтоор ажилласан хугацаа, томилолтын тайлан бичсэн хугацаа зөрүүтэй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.5 дахь заалт" Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоолыг хэрэгжүүлээгүй 608.0 мянган төгрөгийн томилолт авсан эрхлэгч, багш нараар төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

**4.2 Аудитын зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

1.Тус байгууллага нь 2021 онд нийт 534,759.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 424,454.8 мянган төгрөгийн 146 мэдээллийг хугацаанд нь, 110,305.1 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

2. Эмийн тайлангаар 4,216.4 төгрөгийн орлого авч 2,658.7 төгрөгийн зарцуулалтыг хийхдээ эмчийн үзлэгийн карт, эмийн жор бичигдсэн эсэх анхан шатны баримтгүй зөвхөн жагсаалтаар гаргаж зарцуулсан байна. Их эмч Б.Удвал зарцуулсан жагсаалтыг гаргахдаа цэцэрлэг ажиллаагүй саруудад эмийг олгосноор тайлагнасан мөн / Пантоген 500мг дусал 506.0 мянга, ковидын тест 720.0 мянган төгрөгийг зарцуулсан нь анхан шатны баримтгүй байна. /

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", санхүүгийн тайлангийн “бодитой оршин байх”, “Эрх ба үүрэг” Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Эмийн зарцуулалтад хяналт тавьж, анхан шатны баримтыг 2022.05.01-ны дотор дахин шалгуулах, мөн ажилдаа хариуцлагагүй хандсан их эмч Б.Удвалд хариуцлага тооцож ажиллах.

3. Тайлант онд 464,711.4 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 459,679.1 мянган төгрөгийг зарцуулсан, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 38,530.3 мянган төгрөгөөр баталж 36,828.5 мянган төгрөгийг зарцуулж 7,706.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаас 1701.8 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж 6,004.3 мянган төгрөгийг хэмнэх тал дээр удирдлага санаачилгатай ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*

Цаашид байгууллагын удирдлага төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг | 6 | 119,941.7 | | | 3 | 973.7 | | | 1 | 118,968.0 |

______oOo______